



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024.09.24 № 1/912

танай 2024.09.13 ны № 91 -т

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Л.ЭНХ-АМГАЛАН
ТАНАА

“Журам батлах тухай” Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн 06 дугаар тогтоолыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянаж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 6930... дугаарт, “Журам батлах тухай” мөн зөвлөлийн 2024 оны 07 дугаар тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 6931... дугаарт тус тус бүртгэснийг үүгээр хүргүүлж байна.



О.АЛТАНГЭРЭЛ

151603452
Doc.yam a5.2024



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн бүртгэлд
2024 оны 09 сарын 24-ны
өдрийн 6931 дугаарт бүртгэв.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 09 сарын 06 өдөр

Дугаар 07.

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах байгууллагыг сонгох, арга хэмжээний зардлын төлбөрийг санхүүжүүлэх, хяналт тавих журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Тогтоолын хэрэгжилтийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хороотой хамтран зохион байгуулж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Ц.Ганцэцэг)-т даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба (Г.Банзрагч)-нд үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан “Журам шинэчлэн батлах тухай” Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2017 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 10 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Л.ЭНХ-АМГАЛАН

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн
2024 оны 09 дугаар сарын 06-ны өдрийн
07 дугаар тогтоолын хавсралт

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНӨӨС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
БАЙГУУЛЛАГЫГ СОНГОХ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫН ТӨЛБӨРИЙГ
САНХҮҮЖҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа, судалгаа (цаашид “Урьдчилан сэргийлэх арга хэмжээ” гэх)-ны ажлыг зохион байгуулах байгууллагыг сонгох, арга хэмжээний зардлын төлбөрийг санхүүжүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Урьдчилан сэргийлэх арга хэмжээг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хороо, Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газар, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв (цаашид “Байгууллага” гэх) холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулна.

1.3. Байгууллага мэргэжлийн сургалтын байгууллагатай хамтран урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулна. Мэргэжлийн сургалтын байгууллага нь хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт явуулах болон шалгалт авах журам”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын хөтөлбөр”-т тус тус заасан шаардлагыг хангасан, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сургалт зохион байгуулах гэрчилгээ авсан байна.

1.4. Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараа жилийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө (“цаашид төлөвлөгөө” гэх)-г сүүлийн 2 жилийн үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний тайлан мэдээлэлд үндэслэн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хорооны саналыг авч боловсруулан жил бүрийн 12 дугаар сард багтаан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр батлуулна.

Хоёр.Урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион
байгуулах байгууллагыг сонгох

2.1. Байгууллага энэ журмын 1.4-т заасан төлөвлөгөөнд туссан урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах байгууллагыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулна.

2.2. Байгууллага энэ журмын 2.1-д заасан сонгон шалгаруулалтад тэнцсэн байгууллагатай гэрээ байгуулна. Гэрээнд урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг тусгаж батална.

2.3. Байгууллага Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хуульд заасны дагуу ажил үйлчилгээ, худалдан авах үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллана.

**Гурав. Урьдчилан сэргийлэх арга хэмжээний
зардлын төлбөрийг санхүүжүүлэх**

3.1. Урьдчилан сэргийлэх арга хэмжээнд Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт заасан арга хэмжээг хамааруулна.

3.2. Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага Нийгмийн даатгалын сангийн төсвийн тухай хуулиар баталсан урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төсвийн нарийвчилсан хуваарийг баталж, энэ журмын 1.4-т заасан төлөвлөгөө, энэ журмын 2.2-т заасан гэрээг үндэслэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг батлагдсан төсвийн хүрээнд санхүүжүүлнэ.

3.3. Байгууллага урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах байгууллагад энэ журмын 2.2-т заасан гэрээний дүнгийн 60 хүртэл хувиар тооцон урьдчилгаа олгож болох бөгөөд санхүүжилтийг дараах баримт бичгийг үндэслэн олгоно. Үүнд:

3.3.1. энэ журмын 2.1-д заасан сонгон шалгаруулалтын дүн, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах хүсэлт бүхий албан бичиг, ажил гүйцэтгэх гэрээ, хэрэв сургалт зохион байгуулах бол сургалтын хөтөлбөр, арга хэмжээний удирдамж, холбогдох шийдвэрүүд;

3.3.2. урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан, санхүүгийн анхан шатны баримтууд, төлбөрийн нэхэмжлэх.

3.4. Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын үлдэгдэл санхүүжилтийг урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсвийн гүйцэтгэлийн тайлан, анхан шатны баримт бичиг, арга хэмжээний үр дүнгийн тайлан ажил хүлээлцсэн болон гэрээ дүгнэсэн актад үндэслэн гүйцэтгэлээр санхүүжүүлнэ.

**Дөрөв. Урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүн,
төсвийн зарцуулалтыг тайлагнах**

4.1. Урьдчилан сэргийлэх арга хэмжээг гүйцэтгэсэн байгууллага нь уг арга хэмжээний үр дүн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг тухайн арга хэмжээг зохион байгуулж дууссанаас хойш ажлын 7 өдрийн дотор гэрээ байгуулсан байгууллагад ирүүлнэ.

4.2. Байгууллага арга хэмжээний үр дүн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг хүлээн авснаас хойш ажлын 7 өдрийн дотор Нийгмийн даатгалын асуудал

хариуцсан төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

4.3. Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүн, төсвийн гүйцэтгэлийн тайланг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд хагас жил тутамд нэгтгэн тайлагнаж, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хороонд хүргүүлнэ.

4.4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг дараа жилийн эхний улиралд багтаан дүгнэж Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хороонд тайлагнана.

Тав. Хяналт

5.1. Энэхүү журмын хэрэгжилтэд нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл хяналт тавина.

5.2. Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүн, төсвийн гүйцэтгэлийн тайланг хугацаанд нь ирүүлээгүй байгууллагын энэ журмын 3.4-д заасан үлдэгдэл санхүүжилтийг зогсоох, мөн энэ журмын 2.2-т заасан гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авна.

Зургаа. Хариуцлага

6.1. Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---o0o---